



ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/485

Зуунмод

2023 оны Цэргийн бүртгэл  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, “Батлан хамгаалах тухай” хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.1.4, “Цэргийн албаны тухай” хуулийн Есдүгээр бүлгийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.3, 34.6, 36 дугаар зүйлийн 36.2, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Цэргийн бүртгэл явуулах журам”, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын 2023 оны Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Г.Батжаргал	-Сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд:	Р.Цэрэнпагам	-Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
	Г.Уянга	-Цахим үйлчилгээний ажилтан
	Ц.Оюунтүлхүүр	-Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Ц.Алтанцэцэг	-Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Г.Мягмарсүрэн	-Хүний нөөц, гадаад харилцааны ажилтан
	Ч.Цогтмягмар	-Төсөвчин
	Б.Туул	-Номт багийн Засаг дарга
	Н.Мөнх-Өнөр	-Ланс багийн Засаг дарга
	Ш.Цэндсүрэн	-Баянхошуу багийн Засаг дарга
	Ч.Одончимэг	-Зүүндэлгэр багийн Засаг дарга
	Р.Баярсайхан	-Нацагдорж багийн Засаг дарга
	Б.Отгонбаяр	-Баруун Зуунмод багийн Засаг дарга -Багийн Зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар
Нарийн бичгийн дарга:	Ш.Батмөнх	-Соёлын төвийн дарга
	Т.Пансандулам	-Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Сумын хэмжээнд 2023 оны цэргийн бүртгэлийг явуулах ажлын хэсгийн ажил үүргийн хуваарийг 1 дүгээр, цэрэг, техникийн тоо бүртгэл явуулсан тайлан мэдээг нэгтгүүлэх хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ажлын хэсэг (ЗДТГ-ын дарга, Багийн Засаг дарга нар)-т ДААЛГАХ нь:

3.1. Цэргийн бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 20-ны хооронд баг тус бүр дээрээ зохион байгуулж, цэргийн бүртгэлийн мэдээ, судалгааг үнэн зөв гарган хугацаандаа нэгтгүүлэх.

3.2. Иргэдийг цахим мэдээ мэдээллээр хангаж, зар сурталчилгааны ажлыг багийн нутаг дэвсгэртээ зохион байгуулах.

3.3. Багийн өрхийн бүртгэл, хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан цэргийн бүртгэлийг явуулах.

3.4. Цэргийн тоо бүртгэл явуулахдаа цэргийн мэргэжлийн дээд шатны байгууллагаас тоо бүртгэл явуулахтай холбогдуулан гаргасан шийдвэрийг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлэх.

3.5. Иргэдийг мэдээллээр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, нутаг, дэвсгэртээ байгаа 18-50 насны цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицер, ахлагч, чухал мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн цэргийн бүртгэлийн ажлыг багийн Засаг дарга нар гардан хийж маягт №4, маягт №12-ыг үнэн зөв хөтөлж, цэргийн бүртгэлийн мэдээ, явцын талаар мэдээлж ажиллах.

3.6. Цэргийн үүрэгтэн, цэргийн хугацаат болон гэрээт албан хаагч, цэргийн албыг биеэр болон мөнгөн хэлбэрээр дүйцүүлэн хаах иргэд, автотехник, мотоцикль, ангийн буу, агт морьдын судалгаа, тооцоог үнэн, зөв, нарийн чанд гаргах

3.7. Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр хаах гэрээ бүхий иргэдийн төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах

3.8. 2022 онд шинээр 18 нас хүрсэн /2005 онд төрсөн/ иргэдийг бүртгэж цэргийн албанд татагдагчдын анкетыг нээж судалгаа гаргаж ажиллах.

3.9. Багийн байрны халдвар хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, мөрдөж ажиллах.

4. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, цэргийн бүртгэл явуулсан дүн, мэдээ, тайланг сумаар нэгтгэн батлагдсан хуваарийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 31-нд аймгийн Цэргийн штабт зохих журмын дагуу хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.САРАНГЭРЭЛ

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 17/185 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт.

**ЗУУНМОД СУМЫН ХЭМЖЭЭНД 2023 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Зуунмод сумын 2023 оны цэргийн бүртгэл явагдаж байгаа тухай сум орон нутгийн телевиз, вэб сайт ашиглан иргэдэд сурталчилж ажиллах	2023 оны 01 сарын 02-наас 20-ныг хүртэл	Г.Уянга
2	Цэргийн 1, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 18-50 насны иргэдийн нэрийн бүртгэл, нэгдсэн мэдээг гаргахдаа Батлан хамгаалах сайдын тушаалаар баталсан “Бүртгэл явуулах тухай журам”-д заасан маягт хүснэгтийн дагуу хийж гүйцэтгэх	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга, зохион байгуулагч нар
3	Сумын ЗДТГ, албан байгууллага, хэлтэс агентлаг, аж ахуйн нэгжүүдэд ажилладаг цэргийн жинхэнэ алба хаагаагүй алба хаах нас хэтэрсэн иргэдтэй мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах мэдэгдэл өгч, төлбөр төлөх албан хаагчдын судалгааг гаргах	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга, зохион байгуулагч нар
4	Цэрэгт бүртгэлтэй мэргэжлийн болон цэргийн мэргэжил, цолны дугаараар ЦМД-ын кодыг тооцооны хуудас буюу 12 дугаар маягтанд бичиж, цэргийн үүрэгтний үнэмлэх дээр нь “БҮРТГЭВ” тэмдэг дарж, тэмдэглэл хөтлөх	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга нар
5	“Оюутан цэрэг хөтөлбөрт”-т хамрагдсан оюутныг цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийн 1-р зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэж, түүнийг цэргийн жинхэнэ алба хаасанд тооцох, тооцооны хуудсыг нь мэргэжил тус бүрээр нь ялгаж бүртгэх.	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарганар
6	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр алба хаасан иргэдийн нэрсийн жагсаалтыг хүснэгтийн дагуу гаргаж, шинээр боловсруулсан тооцооны хуудсыг бөглөж авч ирэх	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга нар
7	Авто техник, хэрэгсэл, өөрөө явах механизмын маягт өөрчлөгдсөн тул судалгаа гаргахдаа иргэн, аж ахуйн нэгж эзэмшигчийн овог нэр, хаяг, автомашины марк зориулалтыг дэлгэрэнгүй маягтын дагуу гаргаж ирэх	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга, зохион байгуулагч нар
8	2022 онд 18 нас хүрсэн иргэнийг цэргийн бүртгэлд бүртгэж, цэргийн албанд татагдагчдын анкетыг нээх	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга, зохион байгуулагч нар
9	Цэргийн бүртгэлд алба хаах насны бүх иргэдийг хамруулж ажиллах. Хамрагдаагүй иргэдийн нэрсийг гарган Цэргийн штабт ирүүлэх.	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга нар
10	Цэргийн бүртгэлд хамрагдахаар ирсэн иргэдийг хурдан шуурхай бүртгэж тэмдэглэл хийх	2023 оны 01 сарын 20-ны дотор	Багийн Засаг дарга, зохион байгуулагч нар

11	Цэргийн тоо бүртгэлийг хүлээж авах, нэгтгэх өрөө, компьютер, принтерийн хор, цаасаар хангах	2023 оны 01 сарын 20-ны дотор	ЗДТГ-ын дарга
12	Цэргийн тоо бүртгэлийг багуудаас хүлээн авах, нэгтгэх	2023 оны 01 сарын 23-24-ний хооронд	Ш.Батмөнх Т.Пансандулам Р.Цэрэнпагам Г.Уянга Ц.Оюунтүлхүүр Ц.Алтанцэцэг Ч.Цогтмягмар Г.Мягмарсүрэн
13	Цэргийн бүртгэлийн нэгтгэлийг аймгийн Цэргийн штабт хүлээлгэж өгөх ба тооцооны хуудсыг цэргийн мэргэжлийн дугаар болон шилжсэн, нас барсан иргэдийн хуудсыг ангилан хайрцагжуулж авч ирэх	2023 оны 01 сарын 31-нд	ЗДТГ-ын дарга Г.Батжаргал Ш.Батмөнх Т.Пансандулам
14	Багийн дарга нарын ажлын цаг ашиглалтыг шалгах, багуудын ажилд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага тооцох	2023 оны 01 сарын 20-ны дотор	ЗДТГ-ын дарга
15	Сургалт сурталчилгааны ажлыг орон нутагтаа зохион байгуулж явуулах	2023 оны 01 сарын 20-ны дотор	ЗДТГ-ын дарга
16	Цэргийн бүртгэлийн албан бичиг, мэдээ судалгааны баримт бичгийг цэргийн бүртгэлийн дараа эмхлэн архивт тушаах, цэргийн нууц баримт бичиг, нууц, бүртгэв дардас тэмдгийн хадгалалт хамгаалалтад анхаарч ажиллах.	2023 оны 02 сарын 01-нд	Ажлын хэсэг
17	Сумын хэмжээнд 2022 оны цэргийн бүртгэл явуулсан тухай тайланг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах	2023 оны 02 сард	ЗДТГ-ын дарга
18	2023 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн судалгааг гаргаж ИТХ-аар хэлэлцүүлэх	2023 оны 15/III-ны дотор	Т.Пансандулам

**ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР**

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 1198 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт.

**БАГУУДААС 2023 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛ  
ХҮЛЭЭН АВАХ ХУВААРЬ**

№	Багийн нэр	Тайлан хүлээн авах хугацаа	Тоо бүртгэл хүлээн авах буюу тайланг нэгтгэх албан тушаалтан
1	Баянхошуу /3-р/ баг	2023 оны 01 сарын 23-нд	Ш.Батмөнх/Соёлын төвийн дарга Т.Пансандулам /Архив, бичиг хэргийн эрхлэгч Р.Цэрэнпагам /ХШҮДАХМ/ Г.Уянга /Цахим ажилтан
2	Баруун-Зуунмод /6-р/ баг		
3	Зүүндэлгэр /4-р/ баг		
4	Номт /1-р/ баг	2023 оны 01 сарын 24-нд	Ц.Оюунтүлхүүр /НБМ/ Ц.Алтанцэцэг /НБМ/ Ч.Цогтмягмар / Г.Мягмарсүрэн
5	Ланс /2-р/ баг		
6	Нацагдорж /5-р/ баг		

ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР.